

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 сарын 25

Дугаар 01

Улаанбаатар хот

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний Зөвлөлийн 2023 оны анхны хуралдааныг Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот танхимд 2023 оны 05 дугаар дугаар сарын 25-ны өдөр 10.30-12.50 цагийн хооронд амжилттай зохион байгуулав.

Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий Сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргаас өгсөн үүргийн дагуу Зам, тээврийн хөгжлийн сайд, Үндэсний Зөвлөлийн орлогч дарга С.Бямбацогт даргалж, хуралдаанд Үндэсний Зөвлөлийн 14 гишүүдээс 12 гишүүн (Үндэсний Зөвлөлийн даргыг оролцуулаад) танхимаар оролцож, хүндэтгэх шалтгааны улмаас 2 гишүүн цахимаар оролцож, 100 хувийн ирцтэйгээр хуралдлаа. Хуралдаанд ҮЗ-ийн гишүүдээс гадна холбогдох байгууллагуудын асуудал хариуцсан газар, хэлтсийн удирдлагууд, мэргэжилтнүүд оролцлоо.

Хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн сайд, ҮЗ-ийн орлогч дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Тээврийн цагдаагийн албаны дарга Ц.Ариунболд, Нийслэлийн засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн ерөнхий захирал Б.Бүрэнбаатар, захирал н.Баярбаатар, Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Хишигзаяа, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ц.Батгэрэл, БШУЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Цэцэгжаргал, БХБЯ-ны ХБГХХБГ-ын дарга Э.Батболд, ТЦА-ны ЗЦГ-ын Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа М.Ариунболд, ТЦА-ны ЗЦГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ч.Батболд, Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Г.Баярсайхан, ЗХ-ний удирдлагын төвийн захирал С.Адъяасүрэн, ЭМЯ-ны мэргэжилтэн Б.Оролзодмаа, АЖДХ-ны Мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг, ЗТХЯ-ны БТГ-ын дарга Б.Болор-Эрдэнэ, АТБХЗГ-ын дарга Ё.Жаргалсайхан, ЗХАБҮЗ-ийн Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баяржаргал, Ажлын албаны мэргэжилтнүүд оролцлоо.

Хурлыг нээж Зам, тээврийн хөгжлийн сайд бөгөөд ҮЗ-ийн орлогч дарга С.Бямбацогт үг хэлэв.

Тэрээр ЗХАБҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 38 дугаар тогтоол болон хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг тус тус танилцуулав. Үүнд:

- ЗХАБ-ыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан;
- МУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, тулгамдаж буй асуудал;
- Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт /хууль батлагдсанаас хойшхи 10 жилийн хугацаанд/-ийн тайлан;
- “Урьтаж Ухаар” уриан доор зохион байгуулж буй замын хөдөлгөөний аюулгүй байдлын 7 хоногийн аяны тайлан;
- ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэх, батлах /Үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг танилцуулах, батлуулах/;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сан байгуулах, хөтлөх тухай Үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг танилцуулах, батлуулах/.

С.Бямбацогт: Гишүүдэд хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу?

Гишүүд: Саналгүй. Хэлэлцэх асуудлыг дэмжиж байна.

С.Бямбацогт: За хэлэлцэх асуудал дэмжигдлээ. Хөтөлбөрийн дагуу эхний асуудал ЗХАБ-ыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баяржаргал танилцуулна.

Ц.Баяржаргал ЗХАБ-ыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг танилцуулав.

С.Бямбацогт: Хэрэгжилтийн тайлантай холбоотой гишүүдээс асуух асуулт байна уу?

Б.Бүрэнбаатар: Та бүгдэд энэ өглөөний мэнд хүргэе. Тайлангаас харахад хангалтгүй гэж үнэлэгдсэн байна. Бодит үр дүнд хүрсэн ямар ажлууд байна вэ? Тухайлбал, өмнөх оны үзүүлэлтүүдээс сайжирсан, үр өгөөжөө өгсөн сайн жишээнүүд юу байна вэ? Тэр нь юутай холбоотой сайжирсан гэсэн мэдээлэл байна уу?

Ц.Баяржаргал: Нийт ажлын 40 гаруй хувь нь 70-100 хувийн үнэлгээтэй ажлууд байна. Гэхдээ энэ ажлуудад МУ-ын нэгдэн орсон 2 хэлэлцээр, олон улсын төслийн хүрээнд хийгдсэн ажлууд, ялангуяа Тээврийн цагдаагийн албатай хамтран хэрэгжүүлдэг компани ажлууд, нөлөөллийн арга хэмжээнүүд л байна. МУ-ын хэмжээнд 2012 оноос хойш ЗХАБ-ыг хангах Үндэсний стратеги, Үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын бичиг баримтууд батлагдан хэрэгжиж байсан. Мөн ЗХАБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 онд батлагдсан. Эдгээр бодлогын бичиг баримтууд тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн. Харин биелэгдээгүй, тулгамдсан асуудал болоод байгаа ажлуудад ЗХАБ-тай холбоотой эрх зүйн зохицуулалт, ерөнхийдөө хуулийн процедурын шат дараагаас хамааран урт хугацаа шаарддаг ажлууд биелэлт хангалтгүй байдаг. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх тогтолцоо нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Тээврийн хэрэгслийн жолооч, автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн сургалтын тогтолцоог шинэчлэх асуудлыг бид 2012 оноос хойш олон жил ярьж байгаа боловч одоог хүртэл шинэчлэл хийж чадаагүй. Дараагийн асуудал ЗХАБ-ын сургалтын цагийг цэцэрлэг, ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт тусгах ажил хийгдэхгүй байна. БШУЯ-нд холбогдох хүсэлтийг тавьж байсан, шийдэгдээгүй байна. Мөн ЗХАБ-ын мэдээллийн сангийн асуудал байна. Эдгээр асуудалд анхаарах шаардлагатай байна.

С.Бямбацогт: Тодорхой үр дүнд хүрсэн ажлуудаа дурдах хэрэгтэй. Гишүүдээс өөр асуух асуулт байна уу?

Гишүүд: Асуулт байхгүй байна.

С.Бямбацогт: ЗХАБ-ыг хангах 2022 оны тайланг одоо Засгийн газарт танилцуулаад, дараа нь Улсын Их хуралд танилцуулах журамтай. Төлөвлөгөөний хэрэгжилт 55 хувьтай байна. Бид яаж тайлагнах уу? ҮЗ-ийн гишүүд бүгд л Засгийн газрын хуралдаан, УИХ-ын чуулган дээр очиж хамгаална. Одоо яах вэ? Үнэлгээ их доогуур байна? Хэдүүлээ одоо хэрхэн танилцуулах вэ? Энэ дээр ямар гарц, шийдэл байна вэ, Баяржаргал аа?

Г.Ганбаяр: Хэрэгжилт хангалтгүй байгаа нь үнэн. Ер нь Зөвлөл ч бас өмнө нь ковид болон бусад шалтгаанаас хамаарч хуралдаж, идэвхтэй ажиллаж чадаагүй байх. Манайтай холбоотой 2 асуудал байна. Энэ жилийн төлөвлөгөөнд ахиад л орж байна, ахиад л хэрэгжихээргүй байна. Жолооч бэлтгэх асуудлыг яах юм бэ? Эрх зүйн орчных нь хувьд харахгүй бол төлөвлөгөөн дээр дахиад яг хэвээр байна. Жолоочийн сургалт эрхэлдэг сургалтын төвүүдийн зөвшөөрлийг олгох асуудал ХНХЯ-ны чиг үүрэгт байдаг. Сургалтын хөтөлбөрийг нь БШУЯ баталж байна. Жолооч бэлтгэх тогтолцоо чинь боловсрол юм уу, дадал юм уу? Түүнээс эхлэн эрх зүйн орчныг өөрчлөхгүй бол өнөөдрийн эрх зүй хэвээр байх бол өөрчлөлт гарахгүй гэж харж байна. Тэгээд энэ асуудлыг зохион байгуулж байгаа нь ХЗДХЯ-ны харьяа ЦЕГ-ын Лицензийн төв байна. Ингээд 3, 4 байгууллагын дунд яваад байдаг. Хариуцлага, ажлын үр дүн ярихаар эзэн олддоггүй. Салангид, уялдаа холбоогүй байгууллагуудын дунд энэ асуудал шийдэгдэхгүй байна. Тэгэхээр нэгдүгээрт, энэ асуудлыг 2023 оны төлөвлөгөөнд тусгах саналтай байна. Тэгэхгүй бол дахиад л энэ байдлаар орсон байна. Хоёрдугаарт, ЕБС-ийн хүүхдүүдэд зам тээвэр, тэр дундаа ногоон гэрэл, цагаан шугам гээд тодорхой сургалтын хөтөлбөр байгаа, СӨБ, ЕБС-иудад орж байна. Гэхдээ энэ цаг үедээ тохирохгүй байна гэж үздэг. Ялангуяа технологид суурилчихсан, одооны хүүхэд, залуучууд мэдээллийн эринд амьдарч байна. Сургалтын цаг нэмж өгөх тухай хүсэлт ирдэг ч өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангах сургалтын агуулгаа тодорхойлж ирүүлдэггүй. Боловсролын багц хуулинд бусад хуулиар зохицуулж байсан сургалтын хөтөлбөрүүдийг оруулдаг байсан, бид бүгдийг нь хүчингүй болгочихсон. 17 хуульд 49 зүйл, заалтаар сургалтын хөтөлбөрийг оруулдаг байсан. Хог хаягдлын менежментийн Үндэсний Зөвлөлөөс нус, цэрээ хаяхгүй байх тухай сургалтын хөтөлбөр, БОАЖЯ-наас бас сургалтын хөтөлбөрт оруулах сэдвийн санал, ЗТХЯ-наас ЗХАБ-ын сургалтын цагийг хөтөлбөрт тусгах саналыг удаа дараа ирүүлдэг. Гэтэл ЕБС-ийн хүүхдүүдийн мэдээлэл хүлээж авах потенциал, ачааллыг тооцохгүй байна. Тэгэхээр бид өөр арга зам, өөр менежмент хэрэглэх саналтай байна.

С.Бямбацогт: Одоо тулгамдаж буй гол асуудалд шийдэл гаргах нь зүйтэй. Төлөвлөгөөнд төсөв, санхүүжилтгүй ажлууд тусгагдсан, салбар хоорондын уялдаа холбоо муу гэсэн дүгнэлт гарсан байна. Тэгэхээр нэг асуудлыг ч гэсэн шийдвэрлээ гэж зорилго тавин ажиллая. Тухайлбал, тээврийн хэрэгслийн жолоочийн сургалтын тогтолцоог шинэчлэх асуудлыг энэ жил төлөвлөгөөндөө тусгаж, хамтарч шийдлийг гаргая. Жолооч бэлтгэх асуудлыг олон байгууллага хариуцаж байгааг шийдвэрлэх, энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг ХЗДХЯ хариуцаж, манлайлаад ЗТХЯ, ТЦА, ХНХЯ, БШУЯ хамтраад шийдлээ гаргая. Тэгвэл тодорхой үр дүн гарна гэж үзэж байна. Хүн төрсөн цагаас үхэх хүртлээ замын хөдөлгөөнд оролцдог. Энэ бол нийгмийн харилцаанд орох том соёл. Иймээс БШУЯ-ны зүгээр СӨБ болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт ЗХАБ-ыг хангах хичээлийн цагийг тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ бол шийдэх боломжтой асуудал. Өмнөх танилцуулгад сүүлийн 5 жилд зам тээврийн ослын улмаас 284 хүүхэд амь насаа алдсан гэсэн статистик байна. Тухайлбал, хүүхдээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үүднээс суррон, скүүтэр зэргийг унахдаа ЗХД-ийг биелүүлэх шаардлагатай гэсэн мэдээллийг түгээхээр нийгэм, олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглаж үзсэн. Хүүхдүүд тэр бүр эдгээр олон нийтийн сүлжээнд орохгүй, хэрэглэхгүй байна. Тэднээс ЗХАБ-ыг хангах мэдлэгтэй эсэхийг асуухад мэдээлэл тэр бүр хүлээн авч чаддаггүй гэж хариулдаг. Иймд асуудлын ард хариулт байна, хариулт нь шийдэл байя. Энэ жил эдгээр асуудлыг шийдье. Сургалтын хөтөлбөрт хүүхдүүдэд ачаалал үүсгэхгүйгээр тусгах шаардлагатай. Ер нь ҮЗ-өөс тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөн, шийдэлтэйгээр ЗГ бол УИХ-д орох шаардлагатай байна. Өөр зайлшгүй ямар тулгамдсан асуудал байна?

Ц.Баяржаргал: ЗХАБ-ыг хангах 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд байгаа тул төлөвлөгөөг танилцуулахдаа хэлэх саналтай байна сайд аа. Нэмж хэлэхэд, ЗХАБ-ын талаарх сургалтыг хичээлийн бус цагаар долоо хоногт 10 минутаар орох тухай БШУС-ын 2018 оны 184 дүгээр тушаал батлагдсан байдаг. Энэ тушаал яагаад хэрэгждэггүй вэ?

С.Бямбацогт: Ийм тушаал байдаг бол шахаж хэрэгжүүлэе, Үндэсний Зөвлөлийн гишүүд ээ.

Г.Ганбаяр: Тиймээ энэ тушаал байгаа. Гэхдээ хэрэгждэггүй. Учир нь үндсэн үзэх програм хичээлүүд дээр нэмэх цаг нь гарахгүй байна. Нийслэлийн хэмжээнд 56 ЕБС өдөрт 3 ээлжээр хичээллэж байна. Тэгэхээр тэр сургууль, анги танхимд нь ЗХАБ-ын тухай хичээлийг үзэх орчин, цаг хугацаа нь гарахгүй, бодит байдал ийм байна. Сүүлийн үед бидний зүгээс танхимын гэхээсээ илүү цахим сургалтуудыг түлхүү ашиглаж, технологид суурилсан мэдлэг, мэдээллийг өгөхөөр ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан мэдээлэл өгөхөд ахлах ангийн сурагчид хичээлээ сонгон суралцах боломжтой болж байна. Шинэ хичээлийн жилээс эхлээд хэрэгжинэ. Иймд сонгон сурахаар оруулбал үр дүнтэй байх эсэхийг судалж байна.

С.Бямбацогт: Хүн чинь насан туршдаа замын хөдөлгөөнд оролцоно. Тиймээс сонгоод заримд нь сургалт орно, зарим хэсэгт нь орохгүй гэж хаяж болохгүй.

Б.Бүрэнбаатар: Бид нэг ажил хийх гэхээр бусдад даатгаад орхидог. Эцэг эхийн зөвлөл гээд ордон дээр бид Ариунзаяа зөвлөлтэй хамт оролцож байсан. Сургууль болгон эцэг эхийн зөвлөлтэй байдаг. Энэ эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан ЕБС-ийн хүүхдүүдэд энэ боловсролыг олгох боломж байна. Заавал танхимд суугаад, тодорхой цагт багш түүнийг заагаад байхаас илүү эцэг эхээр нь дамжуулан ойлгуулбал үр дүнтэй. Өөрт тохиолдсон жишээгээ хуваалцвал, манай 2 хүүхэд өнөөдөр ямар дугаартай машин явдаг, явдаггүй вэ гэдэг талаар ярьж байсан. Гэтэл хажуугаар тухайн өдөр хориглосон дугаартай автомашин зөрсөн. Энэ үед цэцэрлэгийн 2 хүүхэд тэр автомашин чинь энд явж байна шүү дээ гэж хэлсэн. Үүнийг тайлбарлахад их хэцүү. Ногоон гэрэл ассан байна, зогсоорой гэдэг ч юм уу, энгийн өдөр тутмын амьдрал дээр эцэг эхчүүдээр нь дамжуулан боловсрол олговол зүйтэй. Сургалтын хөтөлбөрт цаг оруулбал хэдэн хичээл орох, яаж үнэлэх, ямар чадвар, дадал эзэмших зэргийг хэн, хэрхэн тогтоох гэдэг асуудал үүсэх магадлалтай. Үүн дээр бид энэ чиглэлд хандсан шторк, контентыг түгээж өгч болно. Дээр нь нэг зүйл хэлэхэд, ТЦА-наас шторк, контентүүдийг түгээхээр орж ирнэ. Аажуу явбал аяндаа хүрнэ, долоо хоногийн аян ч гэдэг юм уу. Нэг аян нь маш богино хугацаатай, долоо хоног явж байгаад л өнгөрдөг. Тогтмол явдаггүй. Тэгэхээр тогтмолжуулаад, улирал, улиралдаа, нөхцөл байдалдаа таарсан байдлаар яаж тасралтгүй явуулах гэдгийг тогтохгүй бол аялал жуулчлалын улирал эхэлнэ, хөдөө орон нутгийн замын ачаалал нэмэгдэнэ, тэр үед чухам яах вэ? Өвөл хальтиргаа гулгааны үе эхэлнэ. Тэр үед яах юм? Энийгээ календарчилсан төлөвлөгөө гаргаад, тодорхой бодлоготой явуулахгүй бол үр дүнд хүрч чадахгүй байна. Ковидын үед маскаа тогтмол зүүх талаар тогтмол контент явуулахад хүмүүст сайн хүрсэн. Тэгэхээр шторк, контентыг байнга түгээж, тасралтгүй явуулж баймаар байна.

С.Бямбацогт: За ойлголоо. Ер нь төлөвлөгөө, тайлан хоёр хоорондоо уялдаатай тул хамтад нь хэлэлцье. ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг ҮЗ-ийн Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баяржаргал танилцуулна. Тэгээд хамтад нь шийдээд явъя. Шийдэлтэйгээр ЗГ, УИХ-д орцгооё.

Ц.Баяржаргал ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулав.

С.Бямбацогт: Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын төсөв нь хаанаас гарах вэ?

Ц.Баяржаргал: 2023 оны төсвийг яамд өөрсдөө хариуцахаар тусгагдсан. Харин 2024 оны төлөвлөгөөний төслийг 2023 оны 08 дугаар сарын 01 гэхэд боловсруулж, эцэслээд төсвийн саналыг ЗГ-т хүргүүлнэ.

С.Бямбацогт: 2022 онд бид хуралдаад, 2023 оны төсөвт энэ зардлуудаа суулгачихсан байх ёстой байсан юм байна, тийм үү?

Ц.Баяржаргал: Тийм.

С.Бямбацогт: 2023 оны төсөв батлагдчихсан тул бид 2023 оны төлөвлөгөөнд туссан ажлаа хэрэгжүүлж чадахгүй. Бүх яаман дээр үүнийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй. Энд тавигдсан мөнгө байхгүй болохоор тодорхой эх үүсвэр олоод зарцуулах юм бол хууль зөрчсөн болно. Зориулалтын бусаар зарцуулсан, төсвийн хууль зөрчих асуудал үүснэ. Өөр шийдэл байна уу?

Ц.Баяржаргал: Мэдээлэл болгож хэлэхэд, 2022 онд яагаад 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаад, төсөв, санхүүжилтийг тусгаж чадаагүй вэ гэхээр ЗХАБҮЗ-ийн Ажлын алба ХЗДХЯ руу шилжсэн, МУ-ын ЗГ-ын 2023 оны 38 дугаар тогтоолоор энэ оны 2 дугаар сард ЗТХЯ-нд буцаж шилжиж ирсэн. Аль яаманд харьяалагдах вэ гэдэг энэхүү асуудлыг шийдвэрлэх гэсээр хугацаа алдсан. Энэ онд нэг иймэрхүү асуудал үүссэн.

С.Бямбацогт: За ойлголоо. Өнгөрсөн 9 сард намайг томилогдох үед ХЗДХЯ-нд шилжинэ гэж байсан. Өнгөрсөн хагас жилийн хугацаанд ХЗДХЯ-нд харьяалагдаж байгаад сая 2 сард буцаад манай яаманд ирсэн байна. Энэ бас нөлөөлсөн байна. Тэгэхээр 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв байхгүй хэрэгжүүлэх бололцоо байхгүй. Иймээс ЗГ-т оруулахдаа ийм ажлууд хийх шаардлагатай байна, ийм төсөв хэрэгтэй байна, хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр чиглэл авах байдлаар танилцуулъя. Үүн дээр тодорхой шийдлээ гаргах хэрэгтэй байна. 2024 оны төсвөө 8 сард өргөн барих үед нь урьдчилж сайн яриад, ҮЗ-ийг хуралдуулж, 2024 онд хийх ажлынхаа төсвийг яам, яамд хариуцаж төсөв дээрээ суулгах ажлаа хийе. 8 сард хуралдах уу?

Ц.Баяржаргал: 2023 оны 8 дугаар сарын 17 гэхэд төсвийн саналыг хүргүүлсэн байх тул 2023 оны 08 дугаар сарын 01 гэхэд төлөвлөгөөгөө эцэслээд, хуралдах саналтай байна.

С.Бямбацогт: 2024 оны төсвийг маш сайн анхаарах шаардлагатай. 2024 оны төсвийн санал болон 2023 оны төсвийн асуудлыг ҮЗ-өөс шийдвэр гаргаад ЗГ-т хүргүүлъя. Төсөвтэй холбоотой асуудлыг ийм байдлаар шийдвэрлэе. Гишүүдэд төлөвлөгөөтэй холбоотой өөр санал байна уу?

С.Адъяасүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Бид нар айхтар их төсөв шаардахгүй ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай гэж бодож байна. ТЦА, манай байгууллагуудаас өдөр тутам зам тээврийн ослын судалгаанд дүн шинжилгээ хийж байна. Манай байгууллагаас ЕБС болон зарим байгууллагууд дээр ЗХД-ийн хэрэгжилттэй холбоотой замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилттэй холбоотой сургалтуудыг зохион байгуулахад эерэг хүлээж авдаг. СӨБ болон ЕБС-ийн хүүхдүүдэд ЗХАБ-ын сургалтыг эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгчийн хамтаар цагдаагийн байгууллага хамтран зохион байгуулж, боловсрол олгож байна. Хүүхдүүдийн тоглоомд нь, хичээлийн сэдэвт нь багтааж ЗХАБ-ын боловсролыг цэцэрлэгийн наснаас эхлэн олгож байна. Жишээ нь: Япон

Улсад ийм байдлаар хүүхдүүдийг сургаж байна. Сургуулийн насанд бол асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, захиргааны байгууллага, цагдаагийн байгууллага бас заавал ЗХАБ-ын сургалтыг хариуцах үүрэгтэй. Тус тусдаа үүрэг хариуцлагыг хүлээнэ. Иймд энэ жишгийг Монгол Улсад нэвтрүүлмээр байна. Түүрүүн жолоочийн сургалтын асуудал хөндөгдсөн. Өнөөгийн байдлаар тээврийн хэрэгслийн жолоочийн сургалтыг 4 яам хариуцаж байна. Сургалт, жолооны курсийн асуудлыг ХЗДХЯ бүрэн хариуцмаар байна. Олон салахаар хариуцах эзэнгүй болоод байна. Жолоочийн сургалтыг олон улсын жишигт нийцүүлмээр байна. Өмнөх 7 хоногт Ерөнхий Сайд манай байгууллага дээр ажилласан. Энэ үеэр жолооч нарыг аттестатчлах талаар яригдсан. Жолооч нарыг аттестатчлах саналтай байна. Жолооч нарын мэдлэг, хандлага муу байна. Сайн сургах шаардлагатай байна. Мөн ахмад настан болон жолооч нарыг давтан сургалтад хамруулмаар байна. Сургалтын цагийн хангалт бас их дутагдалтай байна. Сургалтыг чанаржуулах шаардлагатай, дүрэм журмыг чангатгах шаардлагатай. Гуравдугаарт бодит бүтээн байгуулалт хиймээр байна. Аюулгүй байдлын түвшингээс давсан үзүүлэлт бүхий уулзварууд байна. Ийм уулзварууд дээр автомашин, явган зорчигч хоёрын огтлолцлыг арилгах үүднээс 2 түвшний уулзваруудыг байгуулах саналтай байна.

С.Бямбацогт: За, ерөнхийдөө ойлгосон. Хотын хийх ажлыг ҮЗ-өөр хийлгэх саналтай байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг хот шийднэ.

Б.Солонгоо: Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. ХЗДХЯ дээр өнөөдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. ТЦА, холбогдох албан хаагчид, жолооны сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй ТББ-уудын төлөөлөлтэй жолооны шалгалтын процессыг хялбаршуулах, чанарыг дээшлүүлэх асуудлаар уулзаж байна. Оролцогч талуудын саналыг харахад жолооны сургалтын чанарыг сайжруулах, шалгалт авах процессыг ойлгомжтой, нээлттэй болгох, шалгалт өгч буй иргэддээ хүндрэл чирэгдэл багатай байх гэсэн асуудлуудыг ярилцаж байна. Жолооны сургалтын эрх олгох асуудлыг ХНХЯ хариуцаж байна. Сургалтын хөтөлбөр, агуулга нь БШУЯ-нд харьяалагдаж байна. Ингэхээр салбар дундын асуудал болоод байна. Яамнаас хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа нь сургалтын чиглэлээр ТББ-тай хамтарч ажиллах, жолооч нарыг аттестатчлах, давтан сургах, шалгалт авах асуудлыг нэгдсэн холбоодод нь шилжүүлэх байдлаар зохион байгуулбал төсвийн дарамт багатай, нөгөө талаас уялдаа холбоо, чанар сайжрахад дөхөмтэй байх гэж үзэж байгаа. Эрх хасахтай холбоотой давтан сургах асуудал яригдсан. Манай яаман дээр миний ахалж байгаа шүгэл ажиллагааны хүрээнд яг энэ асуудлаар иргэд саналаа хэлж байна.

С.Бямбацогт: Саналаа хэлээд шийдээд явах уу? Эсхүл танилцуулгаа сонсоод, санал дүгнэлтээ гаргаад явах уу? Тээврийн хэрэгслийн жолоочийг бэлтгэх асуудал бол нэн тулгамдсан асуудал болсон. Тэгэхээр үүнийг энэ жил нэг мөр шийдье гэдэг дээр тогтоод, 5 гол ажлуудыг онцгой анхаарч, үр дүн гаргаж ажиллая. Нэгдүгээрт, тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх тогтолцоог өөрчлөх асуудал, энэ асуудал 4 яамны дунд хаягдаад байна. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх асуудлыг яг хэн хариуцаж ажиллах ёстой гэдгийг ХЗДХЯ судлаад, саналаа бэлтгээд дараагийн хурлаар оруулж, хэлэлцүүлье. Тэгээд холбогдох хуулиудад өөрчлөлт оруулаад, Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэе. Хоёрдугаарт, цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг замын хөдөлгөөнд оролцох соёл, дадалд сургах ажлыг хэрэгжүүлье. Үүнийг БШУЯ хариуцан ажиллаж, холбогдох шийдвэрийг гаргая. Ийм байдлаар өнгөрсөн хугацаанд ярьдаг боловч үр дүн гараагүй 5 ажлыг онцлоод, 2023 онд энэ ажлаа л хийе.

Г.Ганбаяр: С.Бямбацогт сайдын саналыг 100 хувь дэмжиж байна. ЗХАБ-ыг хангах 2023 оны төлөвлөгөөний төслийн 2.2-т байгаа саналыг С.Бямбацогт

сайдын хэлснээр өөрчилье. Сургалтын хөтөлбөр, агуулгад хэрхэн яаж тусгах гэдэг байдлаар томъёоллоо өөрчилье. Мөн 3.7-д тусгасан ажлыг сайдын хэлснээр нэмэлт, өөрчлөлт хийе. Жолооч бэлтгэх тогтолцоо 3 яамны дунд яваад байна. Хуульд өөрчлөлт оруулах, эрх зүйн орчныг өөрчлөх замаар шийдье. Энэ дээр манай яам дангаараа аймаг, нийслэлийн засаг дарга нартай хамтарч ажиллаж байна. Энэ дээр бид ХЗДХЯ болон ЗТХЯ-наас туслалцаа авч, хамтран ажиллах саналтай байна. Ногоон гэрэл, цагаан шугам гээд уламжлал болоод социализмын үеэс эхлэн олон жил явчихсан. Үндсэндээ брэнд болчихсон арга хэмжээ байдаг. Гэхдээ энэ арга хэмжээ олимпиад шиг байдаг, 30 хүүхэд л бэлтгэгддэг. Энэ 30 хүүхдээ л тойроод байдаг, хүүхэд бүрийг хамруулах шаардлагатай. “Ногоон гэрэл, цагаан шугам”, “ЗХАБ-ын Цагаан толгой” арга хэмжээний удирдамжийг боловсруулах ажлыг тусгах саналтай байна. Төлөвлөгөөний төслийн 3.7-д сургалтын тээврийн хэрэгслийг камержуулах ажил байна, манай яаманд хамаарахгүй тул хасах саналтай байна.

С.Бямбацогт: Манайхны хандлага ийм байна. Ерөөсөө л өөрт хамаатай асуудлаа хараад аль болох бусдад түлхэх санаа цухуйлгаад байна. Үр дүн гаргая гэхэд судалгаа танилцуулья аа л гээд Г.Ганбаяр дэд сайд хэлж байна. Хүүхдүүдэд ЗХАБ-ын боловсрол олгох асуудлыг шийдвэрлээд, 2023 оны 9 дүгээр сарын 01-ээс хэрэгжүүлье. Шийдлийг л гаргая.

Г.Ганбаяр: Тиймээ дэмжиж байна. Хөтөлбөрт нь оруулаад, шинэ хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлье.

С.Бямбацогт: За тэгье. Шинэ хичээлийн жилийн хөтөлбөрт суулгана шүү.

Г.Ганбаяр: Тиймээ, тэр томъёоллоор төлөвлөгөөндөө тусгая.

С.Бямбацогт: Төлөвлөгөөний төслийн 3.7 дахь ажлыг хэн хариуцах вэ?

А.Энхболд: Энэ санал ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төв, ХНХЯ-ны сургалт зохион байгуулдаг институтээс ирсэн. Энэ дээр БШУЯ-ыг оруулж ирсний учир нь хөтөлбөрт тусгах ажлыг цаанаас нь зохион байгуулах ажлыг хийдэг. Тэгэхээр энэ дээр ХНХЯ, БШУЯ хариуцаж зохион байгуулна гэдгийг тэр байгууллагуудаас санал хэлж, төлөвлөгөөнд тусгасан.

С.Бямбацогт: ХНХЯ энэ ажлыг ахлаад ажиллая. Бид бүгдээрээ үр хүүхэдтэй, Иймд хүүхдийг багаас нь ЗХАБ-ын мэдлэг, дадалтай болгомоор байна. ҮЗ-өөс энэ ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай. ҮЗ бол иймэрхүү бодлогын том асуудал дээрээ л төвлөрч ажиллах шаардлагатай байна. ҮЗ ажиллаад тодорхой үр дүн гаргачих юмсан гэсэн сэтгэлээр хариуцлагатай ажиллая. ҮЗ-ийн гишүүд хариуцлагаас зугтахгүйгээр энэ чиглэлд хамтарч ажиллана гэдэгт би итгэлтэй байна.

Т.Шинэцэрэг: Сайн байцгаана уу. Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Жолоочийн хариуцлагын даатгалын хууль батлагдсантай холбогдуулан 2011 онд УИХ-ын 43 дугаар тогтоол батлагдсан. Энэ тогтоол дээр “холбогдох яамдад байгаа мэдээллийн сангуудыг жолоочийн даатгалын санд нэгтгэ” гэсэн үүргийг Засгийн газарт өгсөн байдаг. Гэтэл энэ үүрэг өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй. Жолоочийн даатгалын санд холбогдох байгууллагууд дээр байгаа мэдээллүүд нэгтгэгдээгүй. УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх талаар манайхаас холбогдох сайд нарт албан бичиг явуулсан. Иймд ЗТХС болон Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга хамтран баталсан “Зам тээврийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлын даалгавар” гэж гарсан. Энэ даалгаварт тусгагдсан ажлыг ЗХАБ-ыг хангах 2023 оны төлөвлөгөөнд тусгах саналтай байна. Энэ ажилд АЖДХ-ноос 10 тэрбум төгрөг зарцуулахаар тусгасан. Санхүүжилт болон эрх зүйн хувьд ч шийдэгдсэн ажил байгаа. Төсөв

мөнгө нь шийдэгдчихээд байдаг. Яг хаана хийх нь тодорхойгүй байгаад байгаа учраас төлөвлөгөөнд тусгавал сайн байна.

С.Бямбацогт: Хэлэлцэх асуудалд орчихсон байгаа юм байна.

Т.Шинэцэрэг: Энэ дээр байгаа бол биш, өөр.

Ц.Баяржаргал: За дараагаар нь АЖДХ-ныхонтойгоо уулзаад шийдье.

Ц.Ариунболд: Статистик тооноос харахад 2022 онд зам тээврийн ослоор 539 хүн амь насаа алдсан. Үүнээс 487 нь буюу 90 гаруй хувь нь орон нутагт гарсан. Хурд хэтрүүлэх, гүйцэд түрүүлэх үйлдэл хийхдээ осолд өртөж байна. ҮЗ-ийг Монгол Улсын Ерөнхий сайд даргалдаг учир зарим гол ажлын төсвийг Ерөнхий сайдад танилцуулан, Ерөнхий сайдын багц, эсхүл төсвөөс гаргуулах саналыг хүргүүлэх саналтай байна. Орон нутагт хурд хянах камер хиймээр байна. Өнгөрсөн онуудад бид 12 хурд хянах камер хийж, дундаж хурдны камераар хяналт тавиад байна. Нэг хурд хянах камер 100 орчим сая төгрөг байна. Бид энэ онд 39-ийг хийхээр төлөвлөсөн. 3.9 тэрбумын санхүүжилт шийдчихвэл энэ ажлыг эхлүүлвэл, орон нутгийн ялангуяа магистрал замууд дээр хурдыг технологиор хянаад байх юм.

С.Бямбацогт: Бүр байнгын 24 цаг хянах юм уу?

Ц.Ариунболд: Тийм, 24 цаг. А цэгээс Б цэг хүртэлх.

С.Бямбацогт: Тэгэхээр камертай газар чинь хурдаа сааруулчихаад л өнгөрөөд буцаад хурдалчихна шүү дээ.

Ц.Ариунболд: Цэгийн хоорондох хугацаагаар нь дундаж хурдыг нь гаргах юм.

С.Бямбацогт: Энэ дээр чинь иргэд бухимдана. Хурдан явмаар байдаг. Тэгэхээр бид ЗХАБ-ын тухай хуулинд замаас хамааруулж хурдыг 80км/цаг ба 100км/цаг гэж ялгаатай тогтоож болох уу Ё.Жаргалсайхан дарга аа?

Ё.Жаргалсайхан: Осол аваарын тоо огцом өснө. 100-аас дээш гаргаж болохгүй.

А.Энхболд: Энэ дээр нэг тайлбар хийчих үү, сайд аа?

С.Бямбацогт: За тэгье.

А.Энхболд: Ер нь хурдыг ерөнхий, хэсэгчилсэн, нэг бүрчилсэн гэсэн 3 хязгаарлалтаар тодорхойлдог. Тэгэхээр энэ хурд хязгаарлахад авто замын өөрийнх нь хийцийн онцлогийг тооцдог. 80км/цаг хурдтай явж буй тээврийн хэрэгсэлд зориулж авто зам барина шүү гээд ажлын даалгавар хийж, гүйцэтгүүлж байна. Тэгэхээр энэ нь ямар үзүүлэлтээр тооцдог вэ гэхээр зөрж өнгөрөх, хажуугийн аюулгүй байдлын зай зэрэг аюулгүй байдлын үзүүлэлтийг тооцоод, энэ нь өөрөө 80км/цаг хурдтай явах ёстой зам гээд ажлын даалгавартай байна. Швед, Герман улсууд яг манайх шиг ажлын даалгавар өгөөд ийм 80км/цаг хурдтай явна гээд заасан байдаг.

С.Бямбацогт: За манай зам дээр 80 км/цаг-аас илүү хурдтай явж болохгүй юм байна. Тэгэхээр бид аваар ослоос сэргийлэхийн тулд яаж хяналтыг тавих вэ?

Б.Солонгоо: ХЗДХЯ-ны зүгээс камержуулах асуудлыг дэмжиж байгаа. Дундаж хурдны асуудлыг тооцох нь илүү үр дүнтэй гэж харсан. Замын цагдаа зогсож хянахаас илүү камержуулсан нь үр дүнтэй, төсвийн хувьд хэмнэлттэй. Нөгөө талаас орон нутгийн замууд илүү осол болж байгаа томоохон шалтгаан нь иргэд ядарсан үедээ жолоо барьдаг. Үүн дээр ч бас урьдчилан сэргийлэх ажил хийх нь зүйтэй.

С.Бямбацогт: Энэ санал дэмжигдэх боллоо. Ингээд 4 санал боллоо, тийм ээ? Би Ерөнхий сайдад “ЗХАБ-ыг хангах гол 5 ажлын санал тавъя. Та энэ 5 асуудал дээр анхаарч өгнө үү” гээд танилцуулъя. Ийм байдлаар манай Ажлын албаныхан танилцуулах материалаа бэлтгэж өгөөрөй.

Сайд С.Бямбацогт Нисэх хүчин үүсч хөгжсөний 98 жилийн ойн баярт өдрийг тохиолдуулан 12 цагаас УИХ-ын даргад Иргэний нисэхийн тухай хууль өргөн барих ажил давхцсан тул Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболдод хурлыг үргэлжлүүлэн удирдаж, уг хурлаар ҮЗ-ийн хийх 5 гол ажлыг ярилцан, эцэслэн шийдвэрлэх үүргийг өгсөн болно.

С.Энхболд: Гол асуудлуудаа товчхон хэлэлцээд, шийдлийг гаргая. ЭМЯ-наас нэг саналыг тавимаар байна. Хөдөө орон нутагт хүнд, ноцтой осол, гэмтэл гарахад эмнэлгийн тусламж, үйлчилгээг яаралтай үзүүлэх шаардлагатай байдаг. Энэ үед бид Улаанбаатараас мэргэжлийн баг очиж авах шаардлага гардаг. Энэ тохиолдолд нисдэг тэргээр очиж тусламж, үйлчилгээ үзүүлэх, төсөв хөрөнгийг нь шийдвэрлэх, яг аль байгууллагатай нь гэрээ хийх боломжтой, тээвэрлэх боломжтой, нисдэг тэрэг гаргаж өгөх авиа компаниуд хэд байдаг талаар судалж, ийм ослын үед шаардагдах төсвийг шийдвэрлүүлэхээр төлөвлөгөөнд тусгах саналтай байна.

Ц.Ариунболд: Надад 2 санал байна. Нэгдүгээрт, Монгол Улс сүүлийн 10 жилд автомашины тоо огцом өссөн. Тээврийн хэрэгслийн тоо 1,400,000 болчихлоо. Хүн амын тоотойгоо харьцуулбал насанд хүрсэн хүн болгон нэг, заримд нь 2 автомашин ноогдож байна. Иймд ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөн дээрээ автомашины насжилтын асуудал, түүнд тавигдах хязгаарлалтыг бий болгох саналтай байна. Сүүлийн жилүүдэд БНСУ, Япон улсаас автомашиныг импортолж байна. Ихэнх нь техникийн бүрэн бүтэн байдлыг хангахгүй, 15 жил ашигласан хуучин автомашинууд орж ирж байна. Үүнээс үүдэлтэй осол, аваар ч нэмэгдэж байна. Хоёрдугаарт, Монгол Улс дүрмээрээ, хуулиараа бол зүүн гарын дүрэмтэй. Гэтэл баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслүүд дийлэнх хувийг эзэлж байна. Ийм автомашинууд гэрлийн тусгалаас авахуулаад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангадаггүй. Үүнээс импортыг хязгаарлах уу, хориглох уу гэсэн асуудал үүсч байна. Энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

С.Энхболд: Энэ 2 асуудал чухал гэхдээ дэмжлэг авахгүй байх болов уу. Яагаад гэвэл саяхан Түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны хурал дээр нэлээд яригдсан. Насжилттай холбоотой асуудал ард иргэдээс нилээд эсэргүүцэлтэй тулгарна. Баруун, зүүн жолооны хүрдтэй автомашины тал дээр НЗД 2026 оноос тодорхой зохицуулалт хийх талаар ярьсан. Гишүүдээс өөр санал байна уу?

Б.Болор-Эрдэнэ: ЗТХЯ-ны БТГ-ын дарга байна. Би үндэсний зөвлөлийн гишүүн биш боловч санал хэлж болох уу сайдаа, зөвшөөрөл авах гэсэн юм?

С.Энхболд: Бололгүй яахав.

Б.Болор-Эрдэнэ: За баярлалаа. ЗХАБҮЗ байгуулагдснаасаа хойшхи хугацаанд үндсэндээ тогтворжиж, үйл ажиллагаа нь жигдэрч чадалгүй нилээд хэдэн жил боллоо. Үүний гол шалтгаан нь ҮЗ-д төсөв, санхүүжилт байхгүй байна. Нэг ажил хийхэд дандаа харьяа байгууллагууд болон олон улсын байгууллагуудаас дэмжлэг тусалцаа авдаг. Энэ нь тийм ч өндөр дүнтэй байдаггүй тул ажлууд хийгдэхгүй байна. Санхүүжилт байхгүй учраас ажлууд хийгддэггүй талаар түрүүн яригдсан. ҮЗ-өөс гаргадаг “Цагаан ном”-оо ч хэвлүүлэх төсөв байхгүй л сууж байна. ЗТХЯ-ны зүгээс ЗХАБ-ын хангах ажлуудын төсвийг өөрийн төсөвтөө тусгаж хүргүүлдэг, гэвч Сангийн яам дэмжихгүй, хасагддаг. Иймд ҮЗ-ийг өөрийн гэсэн төсөвтэй болгох

асуудлыг шийдэх шаардлагатай байна. Хоёрдугаарт, түрүүн С.Бямбацогт сайд хэллээ. Бид мөнгөгүй хирнээ олон ажлууд төлөвлөдөг. Тэр нь тэгээд дандаа цаасан дээр үлддэг. Тэгэхээр 4-5 гол ажлууд яамдууд хамтраад хийх саналыг дэмжиж байна. Зам, тээврийн осол буурахгүй байна. Зуны улиралд унадаг дугуй, сурронтонтой холбоотой осол аваар нэмэгдэж байна. Энэ асуудалд шийдэл хэрэгтэй байна. АХБ-наас авто замын төлөвлөлтийн үед бидэнд тодорхой шаардлагууд тавьдаг. Олон улсын замын аюулгүй байдлын "3 од"-оос нааш төлөвлөгдсөн замыг бид санхүүжүүлэхгүй, барихгүй гэсэн шаардлага тавьж байна. Хүссэн хүсээгүй бид энэ шаардлагыг хангана. Авто замын хажуу өргөн байх, далангийн налуу нь огцом биш байх гэх зэр маш их шаардлагуудтай байна. Зардлын хувьд харьцангуй өсөхөөр байна. Орон нутгийн авто замд зам засвар, арчилгаанд хөрөнгө санхүүжилт хангалтгүй байгаа нь үнэн. Нийт шаардлагатай санхүүжилтийн 40 орчим хувийг улсын төсвөөс тавьдаг. Та бүхэн мэдэж байгаа, 200-300 км явж байж, авто замын төлбөрт 1000 төгрөг өгдөг. Түүнийг нэмж чадахгүй 10 хэдэн жил боллоо. Нэмээд 3000 төгрөг болгоё гэсэн ч дэмжигдээгүй. Хөдөө орон нутагт хурд хэтрүүлэх асуудлыг бууруулаад, хяналтаа сайжруулчихвал осол аваарын түвшин харьцангуй буурах боломжтой гэж үзэж байна. Иймд замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгсэл, жолооч, авто замын барилга байгууламж гэсэн үндсэн оролцогч болон дэд бүтцийнхээ чиглэлээр нэг нэг гол ажлаа 2023 ондоо анхаараад, хэрэгжүүлэх саналтай байна.

Б.Солонгоо: Цаг хэмнэх үүднээс танилцуулах асуудлууд байгаа юм байна. Иймээс танилцуулах илтгэлүүдээ сонсох саналтай байна. Асуудлуудаа танилцуулсны дараагаар төлөвлөгөөгөө эцэслэх саналтай байна. Нөгөө талаасаа БОАЖЯ-тай хамтраад отоглох цэг байгуулах эсхүл авто замын дагуух үйлчилгээний байгууламжуудыг сурталчлах мэдээлэх, соён гэгээрүүлэх ажил хийх нь зүйтэй.

С.Энхболд: Гишүүд ямар саналтай байна. Эхлээд илтгэлүүдийг сонсох уу? Чухал санаа гарахгүй, нэг асуудлаа тойроод давтаад байна. Б.Солонгоо дэд сайдын хэлдгээр амрах цэгүүдийг таниулах ажил чухал.

Гишүүд: Танилцуулгаа эхлээд сонсоё.

С.Энхболд: 3 танилцуулга үлдсэн байна. Гишүүдийнхээ саналыг хүлээж авлаа. Илтгэгч нар цагаа бариад товчхон танилцуулъя.

ЦЕГ-ын ТЦА-ны ЗЦГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ч.Батболд "Хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал"-ын талаар, АЖДХ-ны Мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг "Жолоочийн даатгалын тухай хууль 10 жилийн хэрэгжилт"-ийн талаар, Ц.Баяржаргал "Урьтаж ухаар" замын хөдөлгөөний аюулгүй байдлын 7 хоногийн тайланг тус тус танилцууллаа.

С.Энхболд: За илтгэгч нартаа баярлалаа. Өнөөдрийн хурлаар танилцуулах мэдээллүүд танилцуулагдлаа. Бид 2023 оны ЗХАБ-ыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг өнөөдрийн хурлаар заавал батлах ёстой. 3 саналтай болсон. 5 гол ажлыг тусгана. Энэ ондоо хэрэгжүүлэх бололцоотой, хагас жилд хийгдэх боломжтой ажлуудыг ярилцъя.

Т.Шинэцэрэг: ЗТХС болон Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга хамтран баталсан "Зам тээврийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлын даалгавар" гэж гарсан. Энэ даалгаварт тусгагдсан ажлыг ЗХАБ-ыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналтай байна. Төсөв нь батлагдаад шийдчихсэн асуудал. Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношлогооны үйл ажиллагааг дэмжих 10 тэрбум төгрөгийг АЖДХ-ноос шийдвэрлэсэн. Нийслэл, ЗТХЯ

дээр тус тус хэрэгжихээр тусгагдсан. Энэ нь цаанаа УИХ-ын 2012 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангана. Үүнийг төлөвлөгөөнд тусгах саналтай.

С.Энхболд: За ЗХАБҮЗАА-тай ярилцаад, нэгтгээд төлөвлөгөөнд оруулъя.

Т.Шинэцэрэг: За тэгье, томъёоллыг нь өөрчлөөд оруулъя.

С.Энхболд: Гишүүд өөр санал байна уу?

Гишүүд: Нэмэх саналгүй. Асуулт байхгүй.

С.Энхболд: За гишүүдээс саналгүй, асуултгүй байна. Гишүүдээс гарсан саналуудаа нэгтгээд Ц.Баяржаргал дарга С.Бямбацогт сайдад танилцуулаарай. Бусад саналуудыг ажлын шугамаар долоо хоногийн дотор авъя. За өнөөдөр ҮЗ маань шинэчлэгдсэн бүрэлдэхүүнээрээ анхны хурлаа амжилттай хийж, санал бодлоо чөлөөтэй солилцлоо. Өнөөдрийн хурлаар хэд хэдэн шийдвэрүүдийг гарган баталгаажуулах ёстой. Ажлын алба болон яамдад тодорхой үүрэг, чиглэлүүд өгөгдөнө. */Шийдвэрлэх асуудлуудыг хойно тусгае./* Өнөөдрийн хурлаа үүгээр өндөрлөө. Цаг заваа гарган ирсэн бүх гишүүд, холбогдох албаны хүмүүстээ баярлалаа. Ажлын шугамаар 2 асуудлыг яаралтай шийдвэрлэх ёстой. Тэгэхээр бүгдээрээ саналуудаа ажлын 5 хоногт багтаан өгөхийг хүсье. Та бүхэнд баярлалаа.

ХУРЛААС ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хурлын тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан, гишүүдийг тараахыг Үндэсний Зөвлөлийн Ажлын албанд даалгах;

2. Хурлаас гарах дараах Үндэсний Зөвлөлийн тогтоолын төслийг албажуулан баталгаажуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Үндэсний Зөвлөлийн Ажлын албанд үүрэг болгох:

- Үндэсний Зөвлөлийн тогтоолын төсөл-1 /“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай/;
- Үндэсний Зөвлөлийн тогтоолын төсөл-2 / Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/;

3. Зөвлөлийн гишүүд өөрсдийн байгууллага дээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан 1 хүнийг томилон өгч, уг хүний мэдээллийг Үндэсний Зөвлөлийн Ажлын албанд албан ёсоор ирүүлэх, байнгын хамтын ажиллагаатай ажиллах;

4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар сарын 01-ны дотор эцэслэн боловсруулж, Үндэсний зөвлөлийн II хуралдааныг 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан зохион байгуулах, 2024 оны төлөвлөгөөнд шаардагдах төсвийн саналыг бэлтгэн, II хуралдаанаар танилцуулахыг Үндэсний Зөвлөлийн Ажлын албанд үүрэг болгох;

5. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, төсвийн асуудалд онцгойлон анхаарах;

6. Үндэсний зөвлөл тодорхой санхүүжилттэй байхгүй бол цааш цаашид төрийн хэмнэлтийн тухай хууль гарчихсан, яамдууд өөрсдийнхөө төсөвт суулгахаар Сангийн яамнаас хасах асуудал нийтлэг байна. Иймд жил бүр тодорхой хэмжээний төсвийг бүрдүүлэх боломжийг судлан, холбогдох арга хэмжээг авахыг Үндэсний Зөвлөлийн Ажлын албанд үүрэг болгох;

7. ЗХАБ-ын талаарх мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ болон бусад арга хэмжээг бэлтгэх ажлыг Үндэсний Зөвлөлийн Ажлын алба, ТЦА болон бусад холбогдох байгууллагуудад даалгах, эдгээр мэдээллийг түгээх ажлыг МҮОНРТ-д үүрэг болгох;

8. Үндэсний Зөвлөлийн нийт гишүүд 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, ослын шалтгаан нөхцлийг бууруулахад онцгой анхаарч, Үндэсний Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачлага гаргаж ажиллахыг үүрэг болгож байна.

9. Үндэсний Зөвлөлийн гишүүдээс бүрдсэн вибэр группыг нээх.

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД БӨГӨӨД
ЗХАБҮЗ-ИЙН ОРЛОГЧ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

АТБХЗГ-ЫН ДАРГА



Ё.ЖАРГАЛСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ЗХАБҮЗАА-ны даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч



Ц.Баяржаргал